



САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО



---

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ - 2020 III

---



Улаанбаатар хот  
2020 он


## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас хөгжиж буй болон хөгжингүй зах зээлтэй орнуудын санхүүгийн зах зээлд макро эдийн засаг болон мөнгө, сангийн бодлогын нөлөөлөх хувьсагч үзүүлэлтүүдийн талаарх судалгааг хийж, холбогдох бодлогын зөвлөмжүүдийг тогтмол олон нийгэд хүргэх ажлыг хийж гүйцэтгэдэг бөгөөд дээрх байгууллагуудаас үнэт цаасны зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүдийг үнэт цаасны зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар, хувьцааны төвлөрөл, зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь, хувьцааны индекс гэсэн үндсэн хэсгүүдэд хуваан авч үздэг.

### 1.1. Зах зээлийн үнэлгээ

Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2020 оны 3 дугаар улирлын байдлаар 2.6 их наяд төгрөг буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.89 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа хэдий ч 2020 оны эхний 9 сарын 3ЗҮ-ний тренд буурсан байдалтай байна.

Зураг 1. Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/



Нийт зах зээлийн үнэлгээний 84.18 хувийг хөрөнгийн биржүүдэд бүртгэлтэй нийт 195 компанийн ердөө 20 компани бүрдүүлж байна. Үүнд:

Хүснэгт 1. 3ЗҮ хамгийн өндөр 30 компани

№	Симбол	Үнэт цаасны нэр	Зах зээлийн үнэлгээ
1	APU	АПУ	605,391,601,870.64
2	TTL	ТАВАН ТОЛГОЙ	300,454,966,000.00
3	MIK	МИК ХОЛДИНГ	264,872,202,800.00
4	INV	Инвескор ББСБ	200,838,170,400.00
5	GOV	ГОВЬ	155,632,443,750.00
6	MDIC	МОНГОЛ ДААТГАЛ	117,041,522,325.00
7	SUU	СҮҮ	72,184,960,000.00
8	BUK	УБ-БҮК	58,538,637,500.00
9	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	56,375,840,094.30
10	SUN	ЕВРОАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ	52,009,537,540.00
11	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	50,537,178,050.00
12	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	39,487,682,940.00

13	GTL	ГУТАЛ	32,049,943,200.00
14	TUM	ТҮМЭН ШҮВУУТ	32,000,000,000.00
15	MFC	МОНОС ХҮНС	28,619,529,960.00
16	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	26,844,968,800.00
17	SHV	ШИВЭЭ ОВОО	26,838,202,000.00
18	BODI	Бодь Даатгал ХК	25,663,968,445.08
19	LEND	ЛЭНДМН ББСБ ХК	23,240,000,000.00
20	BAN	БАГАНУУР	20,974,360,000.00
<b>НИЙТ</b>			<b>2,189,595,715,675.02</b>

### 1.2. Хөрвөх чадвар


Тайлант хугацаанд хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 67 хувиар буурч 1.3 хувьд хүрсэн бөгөөд уг үзүүлэлт буурахад хувьцааны арилжааны хэмжээ 68.3 тэрбум төгрөгөөр буюу 66.2 хувиар буурсан нь нөлөөлжээ. Олон улсын хөрвөх чадварын тухайд гэвэл 2019 оны жилийн эцсээрх нийт 70 улс орны үзүүлэлтийн дундаж үзүүлэлт 26.2 хувь<sup>1</sup> байна. Энэхүү үзүүлэлт Монгол Улсад маш бага түвшинд байгаа нь голчлон хувьцааны төвлөрөлтэй холбоотой байдаг.

Тухайлбал, зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 10 ХК-ийн төвлөрлийг тооцож үзэхэд хэт төвлөрөлтэй /5-аас дээш хувь эзэмшигч/ буюу нийт хувьцааны 90.9 хувийг нийт хувьцаа эзэмшигчдийн ердөө 0.1 хувь нь эзэмшиж байна.

### 1.3. Үнэт цаасны зах зээлийн индексүүд

Монголын хөрөнгийн бирж дээр ТОП-20, MSE-A, MSE-B гэсэн гурван төрлийн хувьцааны үнийн индексүүдийг тооцон гаргадаг. Зах зээлийн үнэлгээ болон хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг нэр бүхий 20 компаниас бүрдэж буй ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 19511.49 нэгж, доод үзүүлэлт 15914.85 нэгж, дундаж үзүүлэлт 17299.11 нэгж байна. ТОП-20 индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,925.9 нэгжээр буюу 9.9 хувиар буурч, 17,531.6 нэгж болсон байна.

Зураг 2. ТОП-20 индекс




Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК

<sup>1</sup> [https://www.theglobaleconomy.com/rankings/stock\\_market\\_turnover\\_ratio/](https://www.theglobaleconomy.com/rankings/stock_market_turnover_ratio/)

ТОП 20 индекст багтаж буй компаниудыг салбараар нь ангилж үзвэл 47 хувийг банк санхүү, 31.3 хувийг аж үйлдвэр, 16.2 хувийг уул уурхай, 3 хувийг харилцаа холбоо, үлдсэн 2.5 хувийг худалдаа үйлчилгээний салбарууд тус тус эзэлж байна.


Мөн Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлийн I, II ангилалд багтсан компаниудын хувьд тоохон гаргаж буй MSE-A болон MSE-B индексүүд өмнөх оны мөн үетэй харьцуулахад мөн адил буурсан үзүүлэлттэй байна. MSE-A индекс өмнөх оны мөн үеэс 841.2 нэгжээр буюу 9.3 хувиар буурсан бол MSE-B индекс өмнөх оны мөн үеэс 50.7 нэгжээр буюу 0.7 хувиар буурсан.

**Зураг 3. MSE-A индекс**



Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК

**Зураг 3. MSE-B индекс**



Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ

### 2.1. Үнэт цаасны зах зээлийн нийлүүлэлт тал

Тайлант хугацаанд Монгол Улсын хөрөнгийн бирж дээр хувьцаа, компанийн бонд, ЗГҮЦ гэсэн 3 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагдсан байна. 2020 оны 3 дугаар улиралд нийт 40.84 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 63.52 хувиар буурсан. Нийт арилжааны үнийн дүнгийн 1.44 хувийг ЗГҮЦ, 13.14 хувийг компанийн бонд, 85.42 хувийг хувьцаа тус тус эзэлж байна.

Үнэт цаасны арилжаа 63.52 хувиар буурсанд хувьцааны арилжаа 66.18 хувь, ЗГҮЦ-ны арилжаа 93.17 хувиар тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Харин хөдөө аж ахуйн биржээр тайлант хугацаанд зөвхөн 4 төрлийн нийт 472.2 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеэс 192.3 тэрбум төгрөгөөр буюу 28.9 хувиар буурсан байна.

#### 2.1.1. Хувьцааны арилжаа

2020 оны 3 дугаар улиралд нийт 34.89 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 66.18 хувиар буурч, 2018 оны 3 дугаар улиралтай харьцуулахад 53.7 хувиар буурчээ.

Хувьцааны арилжаа буурсан нь анхдагч зах зээлийн арилжаа 87.47 хувиар, хоёрдогч зах зээлийн арилжаа 51 хувиар буурсантай холбоотой байна.

Анхдагч зах зээлийн арилжааны хувьд 2019 оны мөн үед “Түмэн шувуут”, “Ард Кредит ББСБ”, “Монос хүнс”, “Инвескор ББСБ” компаниуд IPO хийж, нийт 42.4 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж байсан бол энэ онд “Бодь даатгал” компани IPO хийж нийт 5.3 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

Харин хоёрдогч зах зээлийн арилжааны хэмжээний дүн 2020 оны 3 дугаар улиралд 51.3 хувиар буурсан байна.

Зураг 3. Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа



Дээрх графикаас харвал 2019 оны 3,7 болон 11 саруудад хамгийн их арилжаа хийгдсэн байх бөгөөд үүнд дараах багцын арилжаа нөлөөлсөн байна. Үүнд:

Огноо	Компанийн нэр	Багцын арилжаа хийгдсэн дүн
2019.03.22	АПУ ХК	18.5 тэрбум
2019.07.05	МИК Холдинг ХК	7.3 тэрбум
2019.07.10	МИК Холдинг ХК	7.0 тэрбум
2019.11.22	МИК Холдинг ХК	4.0 тэрбум
2019.11.22	Инвескор ББСБ ХК	1.2 тэрбум
2019.11.25	МИК Холдинг ХК	12.2 тэрбум

Хувьцааны арилжааг хэмжээгээр нь харж үзвэл хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй нийт 195 компанийн ердөө 30 компани нь хувьцааны нийт арилжааны үнийн дүнгийн 97.3 хувийг бүрдүүлж байгаа нийт арилжаанд багцын арилжаа 35.5 хувийг эзэлж байна.

### Хүснэгт 2. Арилжааны хэмжээ хамгийн өндөр 30 компани

№	Компанийн нэр	Арилжааны үнийн дүн
1	Инвескор ББСБ	5,964,720,216.00
2	МОНГОЛ ШУУДАН ХК	3,347,460,949.03
3	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	2,763,298,961.00
4	АПУ	1,780,755,590.02
5	МОНОС ХҮНС	1,582,008,421.40
6	ЖЕНКО ТУР БЮРО	1,552,917,057.87
7	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	1,325,461,518.00
8	ЛЭНДМН ББСБ ХК	1,243,727,960.55
9	МАХИМПЕКС	1,069,915,344.00
10	ХАЙ БИ ОЙЛ	770,602,912.21
11	АРД КРЕДИТ ББСБ ХК	726,523,475.38
12	ГОВЬ	687,572,815.23
13	АРД ДААТГАЛ ХК	678,597,355.06
14	МАНДАЛ ДААТГАЛ	654,565,854.40
15	АДУУН ЧУЛУУН	626,789,391.00
16	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН ХК	546,219,935.83
17	БИ ДИ СЕК	509,946,022.00
18	ТАВАН ТОЛГОЙ	484,770,204.00
19	СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП	484,375,069.54
20	ТҮМЭН ШУВУУТ	263,557,497.68
21	Бодь Даатгал ХК	237,545,240.60
22	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	236,765,980.00
23	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	232,544,659.04
24	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИИ	231,344,480.00
25	МОНГОЛ БАЗАЛТ ХК	159,941,395.37
26	АРИГ ГАЛ	137,022,211.00
27	СҮҮ	128,113,709.31
28	ЭРДЭНЭС СОЛБЮШИНС	118,044,069.66
29	ДАРХАН НЭХИЙ	116,212,257.08
30	ДОРНОД АВТО ЗАМ	100,127,220.00
<b>НИЙТ</b>		<b>28,761,447,772.26</b>

Эх сурвалж: "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Арилжааны алба

### 2.1.1.1.Багцын арилжаа

Тайланг хугацаанд багцын арилжаагаар “Инвекор ББСБ” ХК-ийн 2.3 сая ширхэг хувьцааг 5.1 тэрбум төгрөгөөр, “Женко тур бюро” ХК-ийн 16.2 сая ширхэг хувьцааг 1.5 тэрбум төгрөгөөр, “Монос хүнс” ХК-ийн 14.3 сая ширхэг хувьцааг 1.2 тэрбум төгрөгөөр, “Хай Би Ойл” ХК-ийн 16.6 сая ширхэг хувьцааг 769.0 сая төгрөгөөр, “Адуунчулуун” ХК-ийн 0.6 сая ширхэг хувьцааг 600.3 сая төгрөгөөр, “Монгол шуудан” ХК-ийн 1.0 сая ширхэг хувьцааг 600.0 сая төгрөгөөр, “Ард кредит ББСБ” ХК-ийн 3.5 сая ширхэг хувьцааг 287.5 сая төгрөгөөр, “Лэнд МН” ХК-ийн 5.3 сая ширхэг хувьцааг 250.0 сая төгрөгөөр, “Дорнод авто зам” ХК-ийн 38.8 мянган ширхэг хувьцааг 100.1 сая төгрөгөөр, “Даваанбулаг” ХК-ийн 244.2 мянган ширхэг хувьцааг 48.0 сая төгрөгөөр, “Хөнгөн бетон” ХК-ийн 77.2 мянган ширхэг хувьцааг 17.9 сая төгрөгөөр тус тус арилжсан байна.

Тайланг хугацаанд нийт 10.5 тэрбум төгрөгийн багцын арилжаагаар хийгдсэн нь нийт хувьцааны арилжааны үнийн дүнгийн 35.5 хувийг эзэлж байна.

### 2.1.2.ЗГҮЦ-ны арилжаа

Тайланг хугацаанд ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа явагдаагүй байна. Харин ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлд 5.8 мянган ширхэг үнэт цаасыг 586.9 сая төгрөгөөр арилжсан байна. 2020 оны 2 дугаар улиралд ЗГҮЦ-ны арилжаа 0.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 92.6 хувиар, 2018 оны 2 дугаар улиралтай харьцуулахад 98 хувиар тус тус буурчээ.

### 2.1.3.Компанийн өрийн хэрэгслийн арилжаа

Сүүлийн 2 жилийн хугацаанд Монголын хөрөнгийн зах зээл дээр зөвхөн 2 компани /”Минж проперти” ХХК, “ЛэндМН” ХК/ олон нийтэд санал болгон өрийн хэрэгсэл гаргасан.

“Минж проперти” ХХК нь 1 тэрбум төгрөгийн өрийн хэрэгслийн 2018 онд Хороонд бүртгүүлэн хөрөнгө оруулалтаа амжилттай татан, бондын эргэн төлөлтийг хугацаандаа бүрэн төлж дуусаад байгаа бол “Лэндмн ББСБ” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 17 хувийн хүүтэй нийт 5.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 50.0 мянган ширхэг өрийн хэрэгслийг амжилттай арилжаалснаас хойших хугацаанд нийт 367.6 сая төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

### 2.1.4.Хөдөө аж ахуйн биржийн арилжаа

ХААБ-ээр нийт 472.2 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеэс 192.3 тэрбум төгрөгөөр буюу 28.9 хувиар буурсан үзүүлэлт бөгөөд зөвхөн 4 төрлийн бүтээгдэхүүн арилжигджээ. Үүнд:

Зураг 4. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа



### **2.1.5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас**

Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох зорилгоор 2013 оноос ипотекийн бага хүүтэйгээр орон сууцны зээлийг иргэдэд олгож эхэлсэн. Өнөөгийн байдлаар “МИК ОССК” ХХК-иас 24 тусгай зориулалтын компани /ТЗК/-ийг үүсгэн байгуулж, нийт 83,674 зээлдэгчийн ипотекийн зээлийг үнэт цаасжуулж 4.4 их наяд төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Хороонд бүртгүүлээд байна.

Монгол Улсад хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг үл хөдлөх хөрөнгийн зээлээр баталгаажуулж ирсэн бөгөөд 2020 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 64,536 зээлдэгчийн 3.0 их наяд төгрөгийн баталгаат үнэт цаас байна.

Мөн үүрэн телефоны оператор болох “Жимобайл” ХХК нь 2019 оны 5 дугаар сард хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргасан нь үл хөдлөх хөрөнгийн зээлээс өөр төрлийн санхүүгийн хэрэгслээр баталгаажсан үнэт цаас гаргасан анхны тохиолдол болсон бөгөөд нийт 7.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаас гаргасан.

### **2.2. Үнэт цаасны зах зээлийн эрэлт тал**

Үнэт цаасны хоёрдогч зах зээл эхэлсэнээс хойш төвлөрсөн хадгаламжинд өссөн дүнгээр нийт 2,369,439 шинэ данс, 370,755 холболтын данс нээгдсэн байна. Үүнээс 2,364,070 дотоодын иргэн, 2,323 гадаадын иргэн, 2,849 дотоодын аж ахуйн нэгж, 197 гадаад аж ахуйн нэгжийн данс тус тус нээгдсэн байна.

2019 оны мөн үетэй харьцуулахад нийт дансны тоо 32.5 хувиар нэмэгдсэн ба үүнд “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан ногдол ашиг тараах тухай шийдвэр нөлөөлсөн байна.

#### **2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц**

2019 оны 3 дугаар улирлын байдлаар гадаадын ААН, гадаадын иргэдийн хийсэн арилжаа нийт хийгдсэн арилжааны 29.6 хувийг эзэлж байсан бол 2020 оны мөн үед 25.0 хувийг эзэлж байна.

<b>Он</b>	<b>Гадаадын ААН</b>	<b>Гадаадын иргэн</b>	<b>Дотоодын ААН</b>	<b>Дотоодын иргэн</b>	<b>Нийт</b>
2019III	19.05 тэр ₮	14.11 тэр ₮	42.05 тэр ₮	36.73 тэр ₮	111.94 тэр ₮
	17.02%	12.60%	37.56%	32.82%	100%
2020III	0.21 тэр ₮	7.79 тэр ₮	13.82 тэр ₮	10.14 тэр ₮	31.97 тэр ₮
	0.67%	24.36%	43.25%	31.72%	100%

## **ҮНЭТ ЦААСНЫ ГАЗАР**